



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 03 дугаар сарын 02 өдөр

Дугаар 20

Хэрлэн сум

XX ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 20 дугаар хуралдаан 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 83,3 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Дорнод аймаг дахь салбараас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийг танилцуулах,

*АЗДТГ-ын Олон нийттэй харилцах алба*

2. Шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх эсэх талаар хэлэлцэх,

*Цаагдаагийн газар*

3. Гэрийн ажиглалтад байгаа иргэдийг "GPS CLIX" системээр хянах ажлыг зохион байгуулах бүрэлдэхүүнийг томилох талаар хэлэлцэх,

*Эрүүл мэндийн газар*

4. Улаанбаатар-Чойбалсан чиглэлийн хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний цагийн хуваарийг хэлэлцэж шийдвэр гаргах,

*Автотээврийн төв*

5. Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгт тогооч цалинжуулж ажиллуулах талаар хэлэлцэх,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

6. Шалган нэвтрүүлэх хяналтын цэгт ажиллуулах байр /вагончик/ судалж танилцуулах,

*Аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат*

7. Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн Эхийн амрах байранд хяналт шалгалт хийсэн талаар танилцуулах,

*"Нийтийн аж ахуй" ОНӨААТГ*

8. Хэнтий аймагтай хил залгаа Цагаан-Овоо сумын хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан малчдад урамшуулал олгох эсэх талаар саналыг хэлэлцэх,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

*/ М.Бадамсүрэн*

*/ Х.Баянчим Д.Баттулга*

9."Степ голд" ХХК-ийн тусгаарлах байранд хяналт, шалгалт хийсэн ажлын хэсэг мэдээлэл танилцуулах,

Дорнод аймгийн ерөнхий тархвар судлаач эмч Б.Ганганцэцэг

10.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичиг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.АЗДТГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга,  
Онцгой комиссын гишүүн Э.Батболд-д:

1.1.Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Дорнод аймаг дахь салбараас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Хишиг өдөр нэвтрүүлэг зохион байгуулах тухай" хүсэлтийн дагуу аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт нэвтрүүлгийг 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулахыг зөвшөөрөв,

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.1.Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос баталсан мөрдөгдөж буй тушаал, журмын эмхэтгэл боловсруулж Шуурхай штаб, шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд хувийг хүргүүлэх, шаардагдах зардлыг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас шийдвэрлэхийг,



Аймгийн ерөнхий тархвар судлаач, Онцгой комиссын гишүүн Б.Ганганцэцэг-д:

2.2.Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос баталсан мөрдөгдөж буй тушаал, журмуудын талаар аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб, шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд сургалт зохион байгуулахыг,

АЗДТГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга,  
Онцгой комиссын гишүүн Э.Батболд-д:

2.3.Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр баталсан мөрдөгдөж буй тушаал, журмуудын талаар хэвлэл мэдээллийн бүх төрлийн хэрэгслээр иргэдэд сурталчилах ажлыг зохион байгуулахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

 /М.Бадамсүрэн  
 Д.Баттулга

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Хэрлэн, Баян-Уул, Цагаан-Овоо, Хөлөнбуйр, Баянтүмэн сумын Засаг дарга нарт:

2.4.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаа буюу 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Хэрлэн, Баянтүмэн, Баян-Уул, Хөлөнбуйр, Цагаан-Овоо сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхийг зөвшөөрөв,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг-т.

2.5.Шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдийг Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаа буюу 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл ажиллахад шаардагдах зардлыг тооцож аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт.

2.6.Хэрлэн сум болон уул уурхайн компаниудын ачаа тээвэрлэлтэд хяналт тавих ажлыг үргэлжлүүлэхийг зөвшөөрөв,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт.



2.7.Караоке, баарны үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад халдвар хамгааллын дэглэмийг баримталж ажиллах хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулан аймгийн Онцгой комиссын хуралдаанд танилцуулж ажиллахыг,

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ж.Алимаа,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт.

2.8.Ноолуур бэлтгэх ажлыг зохион байгуулах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн хяналт тавьж ажиллахыг,

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ж.Алимаа-д.

2.9.Ноолуур бэлтгэх, худалдан авах ажлын бэлэн байдлыг хангуулах талаар сумын Засаг дарга нарт чиглэл өгөхийг,

 / М.Бадамсүрэн  
 Д.Баттулга

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Чулуунхороот, Дашбалбар, Баяндун, Баян-Уул сумын  
Засаг дарга нарт:

2.10. Чулуунхороот, Дашбалбар, Баяндун, Баян-Уул сумаас Улаанбаатар хот хоорондын зорчигч тээвэр, ачаа тээврийг Баян-Уул сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгээр хяналттайгаар нэвтрэхийг зөвшөөрөв,

Гурав АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,  
Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,  
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

3.1. Голомттой бүсээс ирсэн иргэдийн гэрийн ажиглалтад хяналт тавих ажлыг эрчимжүүлэхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.2. Иргэдийн зорчих хөдөлгөөнийг хянах зорилгоор гэрийн тусгаарлалтад байгаа иргэдийг холбогдох дүрэм, журмын дагуу "CLIX GPS" гар утасны программыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргахыг,

Сумын Онцгой комисс, Шуурхай штаб,  
сум, багийн Засаг дарга нарт:

3.3. Иргэдийн зорчих хөдөлгөөнийг хянах зорилгоор холбогдох дүрэм, журмын дагуу "CLIX GPS" гар утасны программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, иргэдийг хянах ажлыг зохион байгуулах, мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдыг захирамжаар томилгоожуулж ажиллахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа-д:



3.4. Гэрийн тусгаарлалтад байгаа иргэдийг "GPS CLIX" гар утасны программаар хянах ажлыг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг,

Дөрөв Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын  
гишүүн Ц.Мөнхтөр-д:

4.1. Чойбалсан-Улаанбаатар, Улаанбаатар-Чойбалсан, Улаанбаатар-Дашбалбар чиглэлийн хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг өдөр бүр 08:00 цагт зорчуулахаар зөвшөөрөв,

Тав. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа-д:

5.1. Хөлөнбуйр сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгт ажиллах тогоочийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинжуулж ажиллуулах талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн дараагийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

 / М.Бадамсүрэн  
 Д.Баттулга

Зургаа.Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын  
орлогч дарга Ч.Ганбат-д:

6.1.Шалган нэвтрүүлэх хяналтын цэгт ажиллуулах байр /вагончик/ худалдан авах зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн дараагийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Долоо.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа-д:

7.1.Хөлөнбуйр сумын Эхийн амрах байрны ашиглалтын буруутай үйл ажиллагаанаас болж хуванцар хоолойг хөлдөөж дулааны асуудал үүссэн учир засварлаж хэвийн үйл ажиллагаанд оруулах талаар Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвд албан бичгээр хүргүүлэхийг,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

7.2.Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн Эхийн амрах байрныг ашиглалтын буруутай үйл ажиллагаанаас болж хуванцар хоолойг хөлдөөж дулааны асуудал үүссэн учирсан засварлаж хэвийн үйл ажиллагаанд оруулах талаар Хөлөнбуйр сумын Засаг даргад албан бичгээр чиглэл хүргүүлэхийг

Найм.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

8.1.Хэнтий аймагтай хил залгаа Цагаан-Овоо сумын хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан 5 малчинд нийт 1,300,000 төгрөгийн урамшуулал олгох талаар аймгийн Засаг даргын дараагийн зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Ес.Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын  
гишүүн Б.Ганганцэцэг-д:

9.1."Степ голд" ХХК-ийн уурхайн кемп дэх шаардлага хангасан тусгайлан бэлтгэсэн байранд 6-аас илүүгүй хүнийг тусгаарлан ашиглахыг зөвшөөрөв,

9.2."Степ голд" ХХК-ийн тусгаарлах байраар бэлтгэсэн шаардлага хангасан 40 ортой 10 гэрийг хашаа хийсэн тохиолдолд тусгаарлах байраар ашиглахыг зөвшөөрөв,

Арав.Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Д.Должин-д:

10.1."Петротранс" ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Ээлжийн ажилтнуудыг нэвтрүүлэх тухай" хүсэлтийн дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасаг нь Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 20 дугаар тушаалын дагуу тус компанийн ажилчдыг тусгаарлалтад авах боломжгүй тухай аймгийн Онцгой комиссын албан бичгээр хариу мэдэгдэхийг,

1. Он /М.Бадамсүрэн  
1. Х.Тасаруул /Д.Баттулга

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

10.2.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах талаар сумын Засаг дарга нарт чиглэл өгөхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

10.3.Аймгийн Засаг даргын 2021 оны "Гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай" албан даалгаврыг боловсруулж батлуулахыг,

Арван нэг.Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ж.Алимаа-д:

11.1.Өвөлжилт хүндэрсэн Матад суманд эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэг томилж ажиллуулах талаар Матад сумын Засаг даргад албан бичиг хүргүүлэхийг,

11.2.Мал хамгаалах сангийн хөрөнгөөр бэлтгэсэн аймгийн Аюулгүйн нөөцөд хадгалагдаж буй 8630 боодол өвсийг 3,300 төгрөгөөр, хивэг 1373 шуудайг 11,000 төгрөгөөр, ногоон тэжээл 1085 боодлыг 9,500 төгрөгөөр, жижиглэсэн ногоон тэжээл 780 шуудайг 13,000 төгрөгөөр тус тус зах зээлд борлуулахыг зөвшөөрөв,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:



11.3.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын 132 дугаар салбарын өвс, тэжээлийн нөөцөөс өвөлжилт хүндэрсэн Матад суманд өвс 2500 боодол, Хэрлэн сумын 1,3,5 дугаар багийн айл өрхөд өвс 2500 боодол олгохыг зөвшөөрөв,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа-д:

11.4."Зорчигч тээврийн хөдөлгөөнийг зохицуулах" түр журмыг мэргэжлийн байгууллагын санал авч батлуулахыг,

Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын  
гишүүн Б.Ганганцэцэг-д:

11.5.Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд өдөр тутмын халдваргүйтгэлийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч сургалт зохион байгуулахыг,

 / М.Бадамсүрэн  
 Д.Баттулга

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д;  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт;

11.6.Аймгийн Онцгой комиссын 2021 оны "/COVID-19/ бүртгэгдсэн бүс нутгаас түлш, шатахуун нэвтрүүлэх үйл ажиллагааг түр хориглох тухай" 02 дугаар тогтоолын зөвхөн евро стандартын дизель түлшний тээвэрлэлтийг зөвшөөрөхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА *Х. Баттулга* Д.БАТТУЛГА